МЭДЭЭ · 2021 оны 5-р сарын 7

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРААС ТУС АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗАРТ МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЖЭЭ



Говь-Алтай аймгийн прокурорын газраас сүүлийн 4 жилийн хугацаанд Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй 9 гомдол, мэдээлэлд хяналт тавьж, шийдвэрлэжээ. Тодруулбал, 2017 онд 4, 2018 онд 1, 2019 онд 4 гомдол, мэдээлэлд хяналт тавьсан бол 2020, 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар энэ төрлийн гомдол, мэдээлэл бүртгэгдээгүй байна.

Хяналт тавьсан нийт гомдол, мэдээллийн 7 нь эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл тогтоогдоогүй тул хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 2 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан боловч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлд заасан Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдэгдсэн болох нь тогтоогдоогүй тул хааж шийдвэрлэжээ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах

1.Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол 5.400.000-27.000.000 ТӨГРӨГӨӨР ТОРГОХ, ЭСХҮЛ 1-5 ЖИЛ ХҮРТЭЛ ХУГАЦААГААР ХОРИХ ЯЛ ШИЙТГЭНЭ.

www.prokuror.mn

Дээрх гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэлтийн хэрэгт тус аймгийн Цагдаагийн газрын 10 орчим мөрдөгч холбогдон шалгагдсан бөгөөд бусад төрийн байгууллагын албан хаагч холбогдсон тохиолдол гараагүй байна.

Иймд Говь-Алтай аймгийн прокурорын газраас тус аймгийн Цагдаагийн газарт Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт алба хаагчдыг холбогдохоос урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулж, хариу ирүүлэх талаар мэдэгдэл хүргүүлсэн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2884